



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/494


Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/427 дугаар захирамж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2019 оны А/66 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Монтех дистрибьюшн” ХХК-тай байгуулсан “Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хороодоос үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх тендерийн Багц-1: Компьютер /24ш/, принтер /24ш/ "НХААГ-19/050/1-1 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.
2. Компьютер, принтерүүдийг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг /С.Ариунжаргал/-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 1/ дугаар сарын 25 ны өдрийн 0/494 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	С.Ариунжаргал	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
Гишүүд:	Т.Оюунсүвд	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Г.Амарсанаа	Нийслэлийн Улсын Бүртгэлийн газрын мэдээлэл, технологи хариуцсан инженер /зөвшилцсөнөөр/
	Б.Эрдэнэчимэг	Нийслэлийн Улсын Бүртгэлийн газрын Захиргааны хэлтсийн ахлах мэргэжилтэн бөгөөд ерөнхий нягтлан бодогч /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга:	Х.Сэлэнгэ	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн